



# МҮХАҮТ

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



2022.04.01

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 22.03

## "МОНГОЛ-ЭНЭТХЭГИЙН ХУДАЛДАА, ТЕХНОЛОГИ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ НЬ" БИЗНЕС ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Монгол Улс дахь Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайдын яам, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим хамтран "Монгол-Энэтхэгийн худалдаа, технологи, аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь" бизнес хэлэлцүүлгийг (2022.03.25-нд) зохион байгуулсан бөгөөд оролцогчдын

зүгээс хоёр орны стратегийн түншлэлийг бэхжүүлж, худалдаа, эдийн засаг, уул уурхай, хүнд үйлдвэр, хөдөө аж ахуй, боловсрол, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн байдал болон цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой уулзалт боллоо гэж дүгнэв.



ТӨРИЙН БАНКТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

...

ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ГОЛОМТ БАНКТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА



...



"МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН 2022"-ЫН "ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ" УРДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ МҮХАҮТ-Д ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

...

...

ОХУ-ЫН МОНГОЛ ДАХЬ ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ МАКСИМ ВАСИЛЬЕВТЭЙ УУЛЗАВ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ТУЛГУУРЛАЖ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛНЭ

...

...

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭГГЭСЭН ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА



ХАРВАРД МЕНЕЖМЕНТОР ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨЛТ БОЛЖ, БИЗНЕС АКАДЕМИ ХАРВАРД БИЗНЕСИЙН СУРГУУЛЬТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЛЭЭ

МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес академиас хэрэгжүүлж буй Harvard Business Publishing – ний Harvard ManageMentor (Харвард – МенежМентор) Монгол дахь хөтөлбөрийн төгсөлт 2022 оны 3 дугаар сарын 11-нд болж, 70 орчим компанийн 80 гаруй менежер, дунд, түүнээс дээш шатны удирдлагууд төгсч Харвард Бизнес Паблишингийн сертификатыг гардаж авлаа.


Мөн Бизнес академийн Захирал Д.Асралт тус хөтөлбөрийг тогтвортой үргэлжүүлэх, ахисан түвшний манлайлагчдад виртуал болон Харвардад очиж суралцах 6 модуль бүхий "LEAP" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр "Харвард Бизнес Паблиш" –ын Higher education Дэд Ерөнхийлөгч Brandon Hight –тай санамж бичиг байгуулсан байна.

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

### ТӨРИЙН БАНКТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, бизнесийн орчныг сайжруулах, жижиг дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих, бүтээмжийг дээшлүүлэх, ажлын байр шинээр бий болгох замаар дундаж давхаргыг нэмэгдүүлэх, бэхжүүлэхэд хамтран

ажиллах Санамж бичигт MYXAYT-ын Ерөнхийлөгч О.Амартувшин, Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантер нар гарын үсэг зурлаа.



### ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ГОЛОМТ БАНКТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА

MYXAYT-ын Ерөнхийлөгч О.Амартувшин, Голомт банкны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнес хариуцсан захирал Д.Бадрал нар Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Санамж бичгийн хүрээнд бизнесийн орчныг сайжруулах,

жижиг дунд, бичил бизнес эрхлэгчид болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих, бүтээмжийг дээшлүүлэх, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах юм.



### "МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН 2022"-ЫН "ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ" УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ МУХАҮТ-Д ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



MYXAYT-ын Ерөнхийлөгч О.Амартувшин:

Дотоодын аж ахуйн нэгжүүддээ итгэж, дэмжихгүй бол гадны хөрөнгө оруулагчид яаж итгэж манай улсад хөрөнгө оруулах вэ



MYXAYT-ын дарга Т.Дүүрэн:

Бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ авахдаа дунджаар 6 бичиг баримт бүрдүүлж, З төрийн албан хаагчтай харьцаж, 13 хоног зарцуулж байна



MYXAYT-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Макс группийн Ерөнхийлөгч Д.Ганбаатар:

Хувийн хэвшлийнхэн аль нэг том төслийг төртэй хамтраад хэрэгжүүлье

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



### ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ТУЛГУУРЛАЖ, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОOG ХӨГЖҮҮЛНЭ

Боловсрол, шинжлэх ухааны яам, МҮХАҮТ хамтран "Мэргэжлийн боловсрол ба ажил олгогчдын хамтын ажиллагаа" зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад танхимаар 70 гаруй, цахимаар 100 гаруй оролцогч оролцож, санал солилцов.

Оролцогчдын зүгээс сургалтын төвүүдийг цэгцлэх, хяналт тавих, чадамжийн гэрчилгээ, MCYT гэх ойлголтыг өөрчилж зөв маркетинг хийх, мэргэшүүлэх сургалт, давтан сургалтын талаар саналаа илэрхийлэв.

### ОХУ-ЫН МОНГОЛ ДАХЬ ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ МАКСИМ ВАСИЛЬЕВТЭЙ УУЛЗАВ

МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартувшин ОХУ-ын Монгол дахь худалдааны төлөөлөгч Максим Васильевтэй (2022.03.23-нд) уулзаж, санал солилцлоо. Уулзалтаар хоёр улсын гадаад худалдааны гэрээг

тогтвортой хэрэгжүүлэх, Орос-Монголын худалдааны эргэлтийг цаашид нэмэгдүүлэх зорилгоор үүсээд буй нөхцөл байдлаас үүдэлтэй бодитой хүндрэлийг даван туулахад чиглэсэн олон асуудлыг хэлэлцэв.



### ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭГТГЭСЭН ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг Зөвшөөрлийн тухай хуулийн нэгтгэсэн төслийг хувийн хэвшлийн төлөөлөлд танилцуулж, оролцогчдын асуултад хариулав.

Зөвшөөрлийн тоог БУУРУУЛЖ, зөвшөөрөл авах үйл явцыг ХЯЛБАРШУУЛЖ, ЦАХИМЖУУЛНА. Өргөдөл гаргаснаас хойш 23 хоногийн

дотор шийдвэрлэх, өргөдөл нь аль шатанд байгааг цахимаар харах боломжийг бүрдүүлэх бөгөөд хэрвээ 23 хоногийн дотор багтаан холбогдох шийдвэрийг гаргаагүй бол энгийн зөвшөөрлийг олгосонд, энгийн болон тусгай зөвшөөрлийг сунгасанд тооцох аж.



### МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР: “ЛЕГАЛ ДАТА” ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА

2022 оны 3 дугаар сарын 11-нд Монголын Олон Улсын Арбитрын дарга С.Энхцэцэг болон “Легал data” ХХК-ийн

гүйцэтгэх захирал П.Баттулга нар Хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав.

#### Хамтран ажиллах гэрээний хүрээнд:

- МОУА-аас эрхлэн гаргасан эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа, Арбитрын загвар гэрээ, арбитрын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хүчин төгөлдөр дүрэм, журам болон Арбитраас зохион байгуулж буй сургалтуудыг цахим хэлбэрээр [www.legaldata.mn](http://www.legaldata.mn) цахим санд байршуулах;
- Монголын Олон Улсын Арбитраар нээлттэй шийдвэрлүүлсэн маргааны шийдвэрийг байршуулах;
- Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, хэлэлцүүлэг зэргийг хамтран зохион байгуулах;
- Legaltalks подкастад арбитрын ажиллагаа болон хуулийн технологи сэдэвт ярилцлага хийж нийтэд түгээх;
- Арбитрчдыг [www.legaldata.mn](http://www.legaldata.mn) цахим сангийн гишүүнчлэлийн үйлчилгээнд жилийн эрхийн үнэд хөнгөлөлт үзүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр болов.



## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

### ЁС ЗҮЙТЭЙ МАНЛАЙЛАЛ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



"Бизнесийн ёс зүйн төв"-оос "Ёс зүйтэй манлайлал" уулзалт, хэлэлцүүлгийг (2022.03.25-нд) зохион байгууллаа. Тус уулзалтад MYXAYT-ын дэргэдэх Бизнес академийн Харвард менежментор хөтөлбөрийн төгсөгчдийн холбоо, Эдийн засгийн сэтгүүлч шинжээчдийн клубын төлөөлөл оролцож, Ёс зүйтэй манлайлалд нэгдэхээ илэрхийллээ.

### 4-Р САРД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭ:

- ◆ 4 дүгээр сарын 4  
Судалгааны ерөнхий арга зүйн  
“Судлаач” сургалт (цахим)
- ◆ 4 дүгээр сарын 4  
Харвард МенежМентор хөтөлбөрийн  
3 дахь удаагийн сургалтын нээлт
- ◆ 4 дүгээр сарын 6  
Монгол-Польшийн бизнес уулзалт  
(MYXAYT Их танхим)
- ◆ 4 дүгээр сарын 7-8  
Монголын эдийн засгийн чуулган:  
Шинэ сэргэлт (Төрийн ордон)
- ◆ 4 дүгээр сарын 12  
“Татварын ёс зүй” хэлэлцүүлэг  
(MYXAYT Их танхим)



**Мах махан бүтээгдэхүүний  
технологийн IFFA-2022**  
**Олон улсын үзэсгэлэн**

**Бүртгэл:**  
2022.03.23-аас 2022.04.10-ыг дуустал  
Утас: 7727-7070 (6) 9991-5000, 9904-3129

**1 хүний аяллын үнэ:**  
• УБ-Франкфурт - УБ шууд нислэг  
• Зочид будадан, үзэсгэлэнд орох такс  
• Аяллын даатгал, визний хураамж багтсан

**6.998.000 ₮**  
MYXAYT-ын гишүүн бус: 7.160.500 ₮

**IFFA**  
messe frankfurt